

**ПЛАТО: АГУИН ЕГТЛӨЛ**

**Ц.НЯМСҮРЭН**  
ЭМШУИС, НХУ-ны тэнхим

Энэ бол өрнийн философи дахь хамгийн агуу ёгт лол гэдэгтэй би санал нийлдэг. Агуу ёгтлол маань Платоны Бүгд Найрамдах Улс зохиолын Долоодугаар дэвтрийн 514а-518с хэсэгт бий. Уг зохиолд багтдагаас нь тэр үү эсвэл улс орныг удирдахтай холбогдох тайлбараас нь болоод тэр үү үүнийг улстөртэй ихээхэн холбодог ч танин мэдэхүй, ёсзүйтэй холбогдох тайлал нь хамгаас агуу мэт.

Эл ёгтлолд гинжнээсээ чөлөөлөгдсөн хоригдоор танин мэдэхүйн баатрыг бэлзгэж, танин мэдэхүй ямар хэцүү, адarmaатай, зовлонтой байдгийг дүрслэн үзүүлсэн билээ. Эх зохиолтойгоо танилцсаны дараа энэ талаар арай дэлгэрэнгүй ярилцъя.

\* \* \*

Сократ:-Гэрэл нэвтрэх амтай, туж уруудсан урт хонгилтой газар доорх маш гүн агуйрхуу оромжинд хүмүүс амьдарч байна гэж төсөөл. Хөл хүзүүнээсээ гинжлүүлсэн тэд энэ газар бага балчираасаа байгаа тул хөдөлж ч чадахгүй гагц өөрсдийнхөө өмнө байгаа зүйлийг харна, учир нь мөнөөх гинж тэдэнд толгойгоо эргүүлэх ч боломж олгодсгүй юм. Тэдний ард нилээн дээхнээ асаж буй гал байх агаад хүүхэлдэйн жүжигт хүүхэлдэй тоглуулагчдыг халхалдаг хөшигөрхүү хаалт бүхий зам тэдний хооронд байгаа гэж төсөөл.

Глаукон:-Төсөөлөгдөж байна.

Сократ:-Мод, чулуу, өөр бусад зүйлээр хийсэн хүн, амьтны дурс бүхий янз бүрийн хиймэл зүйлийг энэ хаалтны цаагуур дээр нь харагдахаар барьж яваа хүмүүсийг одоо төсөөл. Тэдний зарим нь ярилцан зарим нь дуугүй явна.

Глаукон:-Хачин дүр, хачин хоригдлууд байна даа.


Сократ:-Харин ч бидэнтэй төстэй. Түрүүчийн байдалтай хоригдлууд агуин хананд тусах сүүдрээс өөр зүйл харах бол уу?

Глаукон:-Толгойгоо ч хөдөлгөх аргагүй бол охоор өөр юу харах вэ дээ?

Сократ:-Хэрвээ тэд өөр хоорондоо ярьдагсан бол харж байгаа мөнөөх сүүдрүүддээ нэр оноох байсан даа?

Глаукон:-Гарцаагүй тэгнэ.

Сократ:-Гяндан нь тэдэн рүү харсан агуин хананаас цуурайтдаг гэж төсөөлье. Тэдний араар мөнөөх хүмүүсийн нэг нь яриад өнгөрөх үед тэд энэ чимээг тэдний нүдний өмнө явж өнгөрсөн сүүдрээс л гарч байна гэж бодно.



Глаукон:-Эргэлзээгүй.

Сократ:-Иймэрхүү байдлаар эдгээр хоригдол мөнөөх хиймэл зүйлсийн сүүдрийг л үнэн гэж ухаарна.

Глаукон:-Энэ бол зайлшгүй.

Сократ:-Гинжнээс чөлөөлөгдвөл юу болсхыг, ямар аргаар мунхагаас ангижруулах ёстойг одоо авч үзье. Тэдний нэгийг гинжнээс нь чөлөөлж, хүчээр босгоод, толгойг нь эргүүлж, гэрэл лүү харуулж өгсүүллээ гэж төсөөл. Энэ бүх хөдөлгөөн түүнд шаналгаатай байх бөгөөд сүүдрийг нь харж байсан зүйлсээ хараадаа түүний нүд маш ихээр гялбэх болно. Хэрэв түүнд урьд утгагүй хоосон зүйл харж байсан, харин одоо бодит байдалд дөхөж, илүү бодитой зүйл рүү хандсанаар арай үнэн үзэлтэй болж байна гэж хэлбэл тэрээр юу хэлэх бол? Дэргэдүүр нь өнгөрөх мөнөөх янз бүрийн зүйлийг үзүүлээд эд юу вэ гэж асууя. Тэрээр балмагдан сандарч, түүнд одоо үзүүлж буй зүйлийг өмнө харж байсан зүйл шиг нь бодитой биш гэж бодохгүй гэж үү?

Глаукон:-Яг тийм, бодитой биш гэж л бодно.

Сократ:-Хэрэв түүнийг галын гэрэл лүү өгц харуулбал нүд нь өвдэж, харж чадах зүйл рүүгээ эргэн хараадаа энэ нь одоо түүнд үзүүлж буй зүйлээс хамаагүй тодорхой юм байна гэдэгт итгэхгүй гэж үү?

Глаукон:-Тэгнэ.

Сократ:-Түүнийг хүчээр дээш чирж, нарны гэрэлд гартаа тавихгүй бол тэрээр зовлонг тэсвэрлэлгүй, ийм хүчирхийлэлд ундууцахгүй гэж үү? Тэгээд ч тэрээр гэрэлд гарагдаа бодитой гэж түүнд хэлж байсан зүйлээс нэгийг нь ч харж чадахгүй болтлоо гялбана шүү дээ.

Глаукон:-Мэдээж, тэр бүгдийг шууд харж чадахгүй.

Сократ:-Дээд ертөнцийн юмыг харахаасаа өмнө дасах хэрэгтэй болно<sup>1</sup>. Хялбараас нь эхлэх хэрэгтэй. Эхлээд юмын сүүдрийг, дараа нь усанд тусах дүрсийг, тэгээд юмыг харах нь хялбар байна. Тэнгэр, эрхэсийг шөнө харах нь амар, өөрөөр хэлбэл сарны гэрэл, оддыг харах нь өдөр Нар, Нарны гэрлийг харахаас хялбар.

Глаукон:-Яг тийм.

<sup>1</sup> Ёсзүйн ойлголтуудыг хэлэлцэж, тэднээр дамжуулж Сайны тухай Санаа руу өгсөхөөс өмнө математикийн сургалтаар дадлагажуулах хэрэгтэйг энд өгүүлсэн. Академийн цэцэрлэгт хүрээлэнд Плато сургуулиа нээсэн бегөөд энэ сургуульд тоо маш чухал байв. Нэгэн сурвалжид өгүүлсэнээр тоо бодож чадахгүй хүн энэ сургуулийн босгыг давах эрхгүй байж. Математикийн арван жилийн сургалт нь адarmaатай ёсзүйн ойлголтуудаас өмнө хийсвэр сэтгэлгээнд оюун ухааныг дасгах зорилготой юм. Болозсрөөгүй ухааныг Софистууд шиг эсвэл Сократ шиг ёсзүйн маргаанд татан оруулах нь буруу гэж Плато үзжээ.

## МУИС Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль

Сократ:-Эцэст нь тэрээр Нар руу харах чэдвартай болж, түүний мөн чанарыг ус юмуу харь өөр орчинд туссанаар нь биш харин төрөлх байдлаар нь төсөөлнө.

Глаукон:-Эргэлзээгүй тэгнэ.

Сократ:-Тэгээд жилийн улирал, он цагийн урсгалыг тогтоож, үзэгдэх ертөнцийн бүх зүйлийг удирддаг, мөн өөрийнх нь болон түүний анд нөхдийн хардаг байсан бүхний шалтгаан нь Нар<sup>1</sup> юм байна гэсэн дүгнэлтийг тэрээр гаргах болно.

Глаукон:-Ийм дүгнэлтэнд эцсийн дүндээ хүрэх нь тодорхой.

Сократ:-Тэрээр хоригдол нөхдөө, урьдын оромжинд нь юуг сэцэн ухаан гэж хүлээн зөвшөөрдөгийг санаад ийн өөрчлөгдсөндөө баярлавч тэднийг өрөвдөхгүй гэж үү? Тэд нэг нэгнээ хүндэтгэн магтаж, сүүдрийг гярхай ажиглан, аль нь цуварч, аль нь зэрэгцэн гарч ирдгийг сайн тогтоож, дараа нь юу гарч ирэхийг зөв таадаг нэгнээ шагнадаг байж. Чөлөөлөгдсэн хоригдол маань тэр шагналыг тэчаадан хүсэх юмуу Агуйд нэр, нөлөөгөө дуурсгасан нэгэнд атаархах бол уу? Хомэрийн Ахиллын адилаар “газар дэлхий дээр үгээгүй нэгний гэрт хөлсний ажилчин шиг” байх бус уу? Хуучин итгэл үнэмшилдээ эргэн орж, урьдынхаараа амьдрахын оронд юуг ч хамаагүй тэсвэрлэх биш үү?

Глаукон:-Тиймээ, өөр ямарч тавиланг уг амьдралаас илүүд үзнэ.

Сократ:-Хэрэв тэрээр Агуй дахь хуучин суудалдаа суухаар дахин тийшээ уруудвал юу болохыг одоо төсөөльье. Нарны гэрлээс гэнэт ангижирсанаар нүд нь таг харанхуйд автана дэа. Сүүдрийн тухай саналаа хэлэх, хэзээ ч чөлөөлөгдөж үзээгүй хоригдлуудтай уралдахыг шаардах үед түүний хараа тогтоогүй, бүдэг байх бөгөөд харанхуйд дастал багагүй хугацаа шаардагдана. Хоригдлууд түүнийг шоолж, дээш гарсанаараа хараагаа муутгасан гэж ярьцааж, дээш гаражыг оролдох ч хэрэггүй гэцгээнэ. Тэднийг чөлөөлж, дээш дагуулах гэсэн хүн гарч нь баригдвал тэд түүнийг алах болно<sup>2</sup>.

Глаукон:-Тиймээ, ална.

Сократ:-За тэгвэл эрхэм Глаукон минь энэ зүйрлэлийн дүрслэл бүрийг өмнөх анализтайгаа тааруулах хэрэгтэй. Шорон оромж бол мэдрэхүйгээр танин баригдах ертөнц, түүн дэх галын гэрэл бол Нарны хүч. Дээд ертөнцийг харах гэж өгсөх нь оюуны ертөнц рүү хийсэн сэтгэлийн аялал. Чиний сонсмоор байгаа, миний хэлэх гээд байгаэ зүйлийг чи дараа ойлгоно.

<sup>1</sup> Нар бол Үнэн, Сайн, Сайхныг бэлзгэнэ.

<sup>2</sup> Плато багш Сократынхаа хувь тавиланг ёгтлон өгүүлжээ.

Зөв эсэхийг нь Тэнгэр мэднэ, гэхдээ би юутай ч ингэж ойлгож байна. Мэдлэгийн ертөнцөд хамгийн сүүлд ухаарагдах, маш бэрхшээлтэй зүйл бол Сайны тухай Санаа юм. Нэгэнт ойлгогдвол энэ нь бүхий л зүйлийн хувьд зөв, буруу бүхнийг тодорхойлдог гэсэн дүгнэлтийг дагуулна. Үзэгдэх ертөнцөд тэрээр гэрэл, гэрлийн эзнийг төрүүлдэг бол оюуны ертөнцөд тэр өөрөө эзэн бөгөөд ухаан, үнэний эцэг байдаг. Эл Санааг ойлгохгүйгээр хэн ч хувийнхаа амьдралд ч, улсын хэрэгт ч ухаалаг зүйлдэж чадахгүй.

Глаукон:-Ойлгохынхoo хэрээр чамтай санал нэг байна.

Сократ:-Тэгвэл энэ өндөрлөгт хүрсэн хүмүүс аахар шаахар хэрэгт оролцоод байдаггүйд гайхах зүйлгүй гэдэгтэй бас санал нийлэх байх. Тэдний сэтгэл бүхий л цагаа тэрхүү дээд ертөнцөд өнгөрүүлэхийг хүсдэг. Давтаж хэлбэл бидний зүйрлэл зөв юм. Тэнгэрлэг бясалгахуйгаас хүний арчаагүй амьдралд буусан хүн харанхуйд нүдээ дасгаагүй байхдаа шүүх, өөр бусад газарт зүй ёсны сүүдэр, тэр сүүдрийг үүсгэдэг дүрийн тухай маргаанд. Зүй ёсыг байгаагаар нь хэзээ ч харж байгаагүй нэгний ухаан дахь зөвийн тухай ойлголтын талаар мэтгэлцээнд хүчээр татагдахдаа инээдтэй харагдах нь тийм ч гайхмаар гэж үү<sup>1</sup>.

Глаукон:-Гайхах зүйл огт алга.

Сократ:-Тэгэхээр гэрэлзэс харанхуй руу эсвэл харанхуйнаас гэрэл лүү шилжих хоёр тохиолодолд хараа алдаж болохыг ухаалаг хүн санах агаад сэтгэлд ч ийм зүйл тохиолдогыг ухаарах болно. Сэтгэл аливааг ялан харж чадахгүй, зүдэрч байгааг ойлгох үедээ тэрээр утгагүй инээхийн оронд гэгээн оршихуйгаас ирээд хараа нь харанхуйд автсан уу эсвэл харанхуйгаас санаад хэтэрхий их гэрэлд гялбасан үү гэдгийг лавлань. Эхний тохиолдолд сэтгэлийн байдал нь атаархал төрүүлэх, амьдрал нь аз жаргалтай юм гэж тэрээр бодно, удаах тохиолдолыг тэр өрөвдөхөөс өөр аргагүй бөгөөд инээдээ барьж дийлээгүй бол энэ нь гэрлээс бууж ирсэн сэтгэлийг шоолохоос арай дээр юм.

Глаукон:-Үнэхээр зөв ярьж байна.

Сократ:-Хэрэв энэ үнэн бол сохор нүдэнд хараа оруулахтай адил мэдлэг үгүй сэтгэлд түүнийг оруулахыг оролддог зарим хүний хэлж байгаа зүйл боловсрол биш гэж дүгнэх ёстой. Үүний эсрэгээр бидний тооцоо хүн бүрийн сэтгэл үнэнийг мэдэх хүчтэй, түүнийг харах хэрэгсэлтэй, нүдээрээ харанхуйг бус гэрлийг харахын тулд бүхэл биөэрээ эргэн харах хэрэгтэйн

<sup>1</sup> Сократыг шүүх ажиллагааг сонсож мэдсэн Калликл шүүхэд философич хүн өөрийгөө өмөөрөх чадалгүй хэмээн түүнийг элэглэжээ.

## МУИС Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль

нэгэн адил сэтгэл бүхэлдээ нүд нь оюуны бодит байдал, Сайн гэж бидний нэрлэдэг тэрхүү сүрлэг дээд зүйлийг тэвчдэг ёолтлоо энэхүү хувиратгай ертөнцөөс эргэх хэрэгтэй. Үүнээс гадна яг энэ зүйлд, хамгийн дөт аргаар сэтгэлийг эргүүлэхэд нөлөөлөх, угаас харах чэдвартай сэтгэлийн нүдэнд түүнийг оруулах биш, харин буруу зүг рүү харуулчилгүй, байх ёстой газар луу нь эргүүлэхийг батлан даах зорилго бүхий урлаг байж болох юм.

Глаукон:-Тийм болтой.<sup>1</sup>

Ёгтполын цаад санааг сайтар ойлгохын тулд Плато, түүний багш Сократын философи үзэлтэй зохих хэмжээнд танилцсан байх хэрэгтэйг юуны өмнө тэмдэглэе.

Санааны тухай Платоны онол ёсоор бидэнд харагдаж буй ертөнц бол жинхэнэ ахуй буюу Санааны ертөнцийн тусгэл, хуулбар, сүүдэр төдий байдаг. Аливаа зүйлийг тодорхойлогч нь түүний Санаа. Бодит ширээ өчнөөн олон янз байж болно. Дугуй, дөрвөлжин, гурвалжин, хөлтэй, хөлгүй гэх мэт. Хэдий ийм олон янз боловч тэр бүгдийг ширээ гэж тодорхойлж буй нийтлэг зүйл бий. Тэр нь биет биш харин санаалаг зүйл. Бодит ширээнүүд үүсдэг, устдаг, эвдэрдэг бол ширээний Санаа хэзээ ч үүсэхгүй, устахгүй, эвдрэхгүй. Нэг үгээр бол үзэгдэх ертөнцөд өөрчлөлт хувиралт байдаг бол Санааны ертөнцөд тийм зүйл байхгүй, энэ бол Мөнхийн Хувирашгүй ертөнц. Энэ Санааг таниагүй цагт аливаа мэдлэг худал, явцуу байна.

Ёгтполд өгүүлсэнээр Сайндын тухай Санаа бол Санааны ертөнцийн маш чухал, гэхдээ ээдрээтэй ойлголт юм. Плато Сайн гээчийг ийн өндөрт үнэлж байгаа нь багш Сократаас нь улбаатай. Үүний цаана Сайн, Сайхан, Үнэн гурвыг салшгүй холбосон маш чамин эрэгцүүлэл оршдог.

Агуйгаас өгсөх зам Үнэний (буюу танин мэдэхүйн) замыг илэрхийлнэ. Чөлөөлөгдсөн хоригдол маань дээд ертөнц буюу жинхэнэ мэдлэгийн ертөнцтэй танилцсаны эцэст агуйд харанхуй хэвээр үлдэгсэдийг өрөвдэн өөрийн эрхгүй буцаж уруудана. Агуй руу уруудах энэ зам Сайндын (буюу ёсзүйн) замыг бэлэгддэг. Энэ нь мэдлэгтэй хүн хэзээ ч мууг үйлдэхгүй гэж үздэг Сократын үзлийг тусгасан хэрэг. Өөрөөр хэлбэл Үнэнийг танин мэдсэн зам Сайныг үйлдэх замаас салангид биш. Үүнийг Плато гайхамшигтай үзүүлжээ.

Гэхдээ үнэнийг танин мэдсэнээр бүх зүйл сайхан болчихгүй гэдгийг ёгтполд бас үзүүлсэн. Жишээ нь чөлөөлөгдсөн хоригдол буюу "танин

<sup>1</sup> Агуйн ёгтполыг Samuel Enoch Stumpf, *Philosophical Problems: Selected Readings* бүтээлээс хөрвүүлэв.

мэдэхүйн баатар" маань үзсэн харсанаа агуйн хоригдлуудад хэлбэл тэдний хэн нь ч үнэмшихгүй байх. Тэдний "толгойд" түүний хэлсэн зүйл "эвлэхгүй" учраас тэд түүнийг галзууд тооцох биз ээ. Өөрөөр хэлбэл үнэнийг хүлээн зөвшөөрүүлнэ гэдэг тийм ч амар биш. Тэгээд ч үнэн гэдэг бидний төсөөлж байснаас огт өөр байх нь олонтоо. Эйнштэйны харьцангуй онол, квант механикийн зарим зарчмууд бодит байдалтай өвцэлдахгүй хачин байдгийг энд жишээлж өгүүлж болох юм. Гэхдээ ёгтлюлд үнэнийг хэрхэн хүлээн зөвшөөрдөг талаар юу ч өгүүлээгүй билээ.

Гэлээ ч энэ бол өрнийн философи дахь хамгийн агуу ёгтлол гэдэгтэй би санал нийлдэг.